

“Нам эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гарган нийтэд мэдээлэх” нийцлийн аудитын тайлан

ОРА-2020/05/-НА

Орхон аймаг дахь Төрийн аудитын газар

2021 он

# СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

## 1. Аудитын нэр

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон “Нам эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гарган нийтэд мэдээлэх”.

## 2. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.” гэж заасныг үндэслэн Орхон аймаг дахь Төрийн аудитын газар нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг хянаж баталгаажуулсан.

## 3. Аудитын зорилго

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчдээс төвлөрүүлсэн орлого, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, сонгуулийн зардлыг хянаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, нийтэд мэдээлнэ.

## 4. Аудитын хамрах хүрээ

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланд хийсэн аудитын дүгнэлт, аудитын дэлгэрэнгүй тайлан, аудит хийгдсэн сонгуулийн зардлын тайлангийн маягтууд, харилцагч банкны дансны хуулга бусад шаардлагатай баримтуудыг хамарсан.

## 5. Арга зүй

Аудитын ажлыг гүйцэтгэхэд нам, эвслээс оруулсан хөрөнгө, иргэн, хуулийн этгээдээс авсан хандив түүний зарцуулалтын тайланг шалгаж, аудит хийсэн хуулийн этгээд, нам, эвсэл, нэр дэвшигчдээс лавлагаа, тодруулга авч, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж тайланг бэлтгэв.

## 6. Үндсэн мэдээлэл

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн 47 тойрогт /Орхон аймгийн ИТХ-ын 23 тойрог, Баян-Өндөр сумын ИТХ-ын 21 тойрог, Жаргалант сумын ИТХ-ын 3 тойрог/ давхардсан тоогоор 5 намаас 201 иргэн, бие дааж 20 иргэн нийт 221 хүн нэр дэвшсэн байна. Үүнд:

№	НАМ, ЭВСЛИЙН НЭР	Орхон аймаг		Баян-Өндөр сум		Жаргалант сум		Нийт	
		Тойргийн тоо	Нэр дэвшигчийн тоо	Тойргийн тоо	Нэр дэвшигчийн тоо	Тойргийн тоо	Нэр дэвшигчийн тоо	Тойргийн тоо	Нэр дэвшигчийн тоо

1	Монгол ардын нам	23	35	21	31	3	21	47	87
2	Ардчилсан нам	19	30	21	31	3	20	43	81
3	Монгол ардын хувьсгалт нам	5	7	10	11	2	5	17	23
4	Хөдөлмөрийн үндэсний нам	3	3					3	3
5	Шударга - Иргэдийн нэгдсэн эвсэл нам	6	6			1	1	7	7
6	Бие даан нэр дэвшигч	10	18	2	2			12	20
	<b>Нийт</b>	<b>66</b>	<b>99</b>	<b>54</b>	<b>75</b>	<b>9</b>	<b>47</b>	<b>129</b>	<b>221</b>

Дээрхээс аймгийн ИТХ болон сумын ИТХ-д нийт 7 иргэн давхар нэр дэвшсэн байна. /Б.Зоригтбаяр – МАН, Д.Ганболд, Д.Гантөмөр – АН, С.Батсайхан, Г.Оюунбат – МАХН, Д.Батбаяр – ШИНЭН, Б.Эрдэнэхүү – Бие даан нэр дэвшигч/.

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслээс сонгуулийн зардлын тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлсэн 3 намын данс эхний үлдэгдэлгүй ба сонгуулийн зардлын тайлангаар нийт 56,611.6 мянган төгрөгийн орлого, 56,602.5 мянган төгрөгийн зардал тайлагнаж, харилцах дансны үлдэгдэл 9.1 мянган төгрөг /МАН/, өр төлбөр тайлагнаагүй байна.

Мөн сонгуулийн зардлын тайлангаа ирүүлсэн 172 нэр дэвшигчдийн дансанд нийт 593,330.8 мянган төгрөгийн орлого төвлөрч, сонгуулийн үйл ажиллагааны зардалд 578,293.3 мянган төгрөг зарцуулж, харилцах дансанд 15,091.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, 2,061.8 мянган төгрөгийн төлөгдөөгүй өр төлбөр тайлагнасан байна.

Сонгуульд оролцсон намуудад 16 иргэн 12,314.0 мянган төгрөгийн мөнгөн хандив, нэр дэвшигчдэд нам, эвслээс оруулсан хөрөнгө 1,380.0 мянган төгрөг, нэр дэвшигчдийн өөрийн хөрөнгө 151,854.9 мянган төгрөг, 26 хуулийн этгээдээс 38,419.4 мянган төгрөг, 1234 иргэн 401,676.5 мянган төгрөг хандивласан байна.

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/15 дугаар тушаалаар Орхон аймгийн сонгуулийн тойрогт нам, эвслээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг 462,663.4 мянган төгрөгөөр, Баян-Өндөр сумын сонгуулийн тойрогт нам, эвслээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг 187,834.4 мянган төгрөгөөр, Жаргалант сумын сонгуулийн тойрогт нам, эвслээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг 52,737.9 мянган төгрөгөөр, нэр дэвшигчдийн зарцуулах зардлын дээд хэмжээг тухайн тойргоос хамааран 9,031.2 мянган төгрөгөөс 34,624.9 мянган төгрөгөөр тус тус тогтоосон ба сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчид тогтоосон хэмжээнд зардал гаргасан байна.

## **Бүлэг 1: Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан.**

### **1.1 Сонгуулийн зардлын дансны орлого зардал**

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-д “Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.” гэж заасны дагуу нэр дэвшигчээр бүртгэгдсэн 221 иргэнээс 7 нэр дэвшигч аймаг, сумын ИТХ-д давхар нэр дэвшсэн давхардаагүй тоогоор 214 нэр дэвшигчээс сонгуулийн зардлын тайлангаа хугацаандаа ирүүлсэн 171, хугацаа хоцроож ирүүлсэн 1 /С.Дэнсмаа – 5-р тойрог – ХҮН/, тайлангаа ирүүлээгүй 42 нэр дэвшигч байна.

Сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-д “Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй нэр дэвшигчдийн мэдээллийг хавсралт 1.7-с үзнэ үү.

Сонгуулийн зардлын тайлангаа ирүүлсэн 172 нэр дэвшигчид бүгд хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулж баталгаажуулсан байна.

Эдгээрээс 15 тайлан орлого, зарлага тайлагнаагүй “х” тайлан, 17 тайлан 3.0 мянган төгрөг хүртэлх зардал гаргасан бол арван сая төгрөгөөс дээш зардал тайлагнасан 13 тайлан байх бөгөөд хамгийн дээд тал нь 14,893.7 мянган төгрөгийн зардал тайлагнасан байна. /Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 1.1 болон 1.2-с үзнэ үү./

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3-д “Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж бүртгүүлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу дансны дугаар, банкны нэрийг бүртгүүлсэн 219 нэр дэвшигч, бүртгүүлээгүй 2 нэр дэвшигч /Ч.Ариунгэрэл – АИТХ-н 8-р тойрог-МАХН, Р.Батчимэг – Жаргалант сумын ИТХ-н 1-р тойрог-МАХН/ байна.

Нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансны үлдэгдэл нь сонгуулийн зардлын тайлангаа ирүүлсэн өдрийн байдлаар 15,091.5 мянган төгрөг байна. /Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 1.5-с үзнэ үү./

Нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлангаарх нийт орлого 593,330.8 мянган төгрөгийг орлогын төрлөөр харуулбал.

ОРЛОГЫН ТӨРӨЛ	ОРЛОГО /мян. төгрөг/				НИЙТ	
	Тоо	Мөнгөн	Тоо	Мөнгөн бус	Тоо	Дүн
Нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө	14	1,380.0			14	1,380.0

Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө	95	151,854.9			95	151,854.9
Хуулийн этгээдийн хандив	26	38,419.4			26	38,419.4
Иргэний хандив	1,234	401,676.5			1230	401,676.5
<b>ДҮН</b>	<b>1,369</b>	<b>593,330.8</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>1,365</b>	<b>593,330.8</b>

Нэр дэвшигчид сонгуулийн үйл ажиллагааны зардалд нийт 578,239.3 мянган төгрөг зарцуулсныг зардлын ангиллаар харуулбал.

<b>ЗАРДЛЫН АНГИЛАЛ</b>		<b>МӨНГӨН ДҮН /мян. төгрөг/</b>
<b>НИЙТ ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>578,293.3</b>
<b>2.1 Сонгуулийн зардлын дүн</b>		<b>556,673.3</b>
2.1.1.	Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах	216,338.0
2.1.2.	Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал	4,259.9
2.1.3.	Намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал	890.4
2.1.4.	Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал	4,930.0
2.1.5.	Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал	293,658.4
2.1.6.	Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах	12,049.5
2.1.7.	Цахим орчин ашиглах зардал	3,416.0
2.1.8.	Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал	21,131.1
<b>2.2 Бусад зардлын дүн</b>		<b>21,566.0</b>

Нэр дэвшигчдийн зардлын тайланд ухуулагчдад олгосон цалин хөлсний ХХОАТ-н болон байрны түрээсийн төлөгдөөгүй байгаа нийт 2,061.8 өр төлбөр тайлагнасан байна. Аудитын явцад 68.3 мянган төгрөгийн өглөг төлөгдсөн. /Дэлгэрэнгүйг хавсралт 1.4/

### **1.2 Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив.**

Сонгуулийн зардлын тайлангаар 95 нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансанд хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээлэл дутуу, буцах хаяг тодорхойгүй зэрэг шалтгаантай 91,979.1 мянган төгрөгийн хандивын орлого орсон байна.

Дээрхээс 70 нэр дэвшигч сонгуулийн зардлын эцсийн тайлангаа гаргахаас өмнө нийт 64,204.3 мянган төгрөгийг хуулийн дагуу хандивлагч этгээдэд буцаан шилжүүлсэн ба улсын орлого болгосон хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив байхгүй байна.

Нийт 39 нэр дэвшигч хуулиар зөвшөөрөгдөөгүй 27,774.8 мянган төгрөгийн хандивыг сонгуулийн зардлын тайлан гаргахаас өмнө хандивлагч этгээдэд буцаагаагүй болон улсын орлого болголгүйгээр зарцуулсан байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 1.3/

Энэ нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.4-д “Хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээд нь нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээллээ банкны гүйлгээний баримтад тусгах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй хандивыг хандив хүлээн авагч буцаан шилжүүлнэ.”, 55 дугаар зүйлийн 55.2-д “Хандив өгөхийг хориглосон этгээд болон эрх зүйн байдал нь тодорхойгүй этгээд сонгуулийн хандив өгсөн бол хандив хүлээн авах эрх бүхий этгээд буцаан шилжүүлнэ.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд уг зөрчлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн А/19 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ын 20.4-д “Нам, эвсэл, нэр дэвшигч энэ журмын 12.1, 15.5-д заасан мөнгөн хөрөнгийг улсын орлого болгоогүй тохиолдолд уг зөрчлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газар холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлнэ” гэсэн заалтын дагуу аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс болон Татварын хэлтэст энэхүү тайлангаар шилжүүлж байна.

### **1.3 Сонгуулийн зардлын тайланд хийсэн аудитын илрүүлэлт:**

Аудитын хуулийн этгээдүүд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн А/55 дугаар тушаалаар баталсан “Сонгуулийн зардлыг тайлагнах заавар, аргачлал”, Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн А/19 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ын дагуу аудит хийж баталгаажуулсан тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газар дахин хянаж тайлагналтай холбоотой алдааг залруулсан байна.

Сонгуулийн зардлын тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд болон анхаарал татахуйц дараах асуудлууд илэрсэн байна. Үүнд:

- Хуулиар зөвшөөрөгдөөгүй 27,774.8 мянган төгрөгийн хандивыг хандивлагч этгээдэд буцаах болон улсын орлого болгоггүй зарцуулсан,
- Нэр дэвшигч сонгуулийн зардлын дансаараа бус хувийн дансаараа 970.0 мянган төгрөгийн хандив хүлээн авч зарцуулсан,
- Сонгуульд оролцохтой холбоотой орлого, зардлын бүх гүйлгээгээ сонгуулийн зардлын дансаараа дамжуулж зарцуулсан эсэхийг бүрэн тодорхойлох боломжгүй,
- Аудитын хуулийн этгээд сонгуулийн зардлын тайлангаа “Хязгаарлалттай санал дүгнэлт” гэж гаргасан,
- Анхан шатны баримтыг сонгуулийн зардлын тайланг гаргаснаас хойш нөхөж бүрдүүлж авсан болон анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.
- Сонгуулийн зардлын тайлангийн баримтуудыг иж бүрэн ирүүлэхгүй байх, олон дахин нэхэж шаардуулах, хугацаа алдуулах.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5-д “Сонгуулийн зардлын данс байршуулсан

банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.” гэж заасны дагуу нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансны хуулгыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхээс ХААН банк хуулийн хугацаандаа ирүүлсэн бөгөөд Голомт, Төрийн, Хас, Капитрон, Худалдаа хөгжлийн банкууд сонгуулийн зардлын дансны хуулгыг ирүүлээгүй байна.

Энэ нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5-д “Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.” гэсэн заалтыг зөрчиж байна.

#### **1.4 Нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн мэдээлэл.**

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож буй нэр дэвшигчдэд давхардсан тоогоор 7 хуулийн этгээд 33,409.2 мянган төгрөгийн /хоёр сая ба түүнээс дээш төгрөг/, 175 иргэн 261,957.4 мянган төгрөгийн /нэг сая ба түүнээс дээш төгрөг/ хандив өгсөн байна. /Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 1.6-аас үзнэ үү./

#### **1.5 Хувийн аудитын хуулийн этгээдийн дүгнэлт:**

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нам, эвслээс болон бие даан нэр дэвшигчдийн аудитын хуулийн этгээдээр баталгаажуулсан 172 сонгуулийн зардлын тайлангаас үнэн зөв, иж бүрэн илэрхийлэгдсэн 169, үнэн зөв, иж бүрэн илэрхийлэгдээгүй 3 дүгнэлт /Хязгаарлалттай санал дүгнэлт/ гарсан байна.

### **Бүлэг 2: Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын тайлан.**

#### **2.1 Сонгуулийн зардлын дансны орлого, зардал**

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-д “Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.” гэж заасны дагуу сонгуулийн зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан хугацаандаа ирүүлсэн 2 /МАН – Далайван аудит ХХК-ийн Орхон аймаг дахь салбараар, Ардчилсан нам – ЦЭСБ-Аудит ХХК-аар дүгнэлт гаргуулсан/, хандив хүлээн аваагүй, орлого, зардлын гүйлгээ гараагүй талаар тайлбар, тайлан ирүүлсэн 1 /МАХН/, хандивын данс нээлгээгүй, орлого, зардлын гүйлгээ гараагүй талаар албан бичиг хугацаа хоцроож ирүүлсэн 1 /ХҮН/ нам байна.

Нам, эвслийн сонгуулийн зардлын тайлангаарх нийт орлого 56,611.6 мянган төгрөгийг орлогын төрлөөр харуулбал.

ОРЛОГЫН ТӨРӨЛ	ОРЛОГО /мян.төгрөг/				НИЙТ	
	Тоо	Мөнгөн	Тоо	Мөнгөн бус	Тоо	Дүн

Нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө	1	44,297.6			1	44,297.6
Хуулийн этгээдийн хандив					0	0.0
Иргэний хандив	16	12,314.0			16	12,314.0
<b>ДҮН</b>	<b>17</b>	<b>56,611.6</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>17</b>	<b>56,611.6</b>

Нам, эвсэл сонгуулийн үйл ажиллагааны зардалд нийт 56,602.5 мянган төгрөг зарцуулсныг зардлын ангиллаар харуулбал.

<b>ЗАРДЛЫН АНГИЛАЛ</b>	<b>МӨНГӨН ДҮН /мян.төгрөг/</b>
<b>НИЙТ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>56,602.5</b>
<b>2.1 Сонгуулийн зардлын дүн</b>	<b>56,590.6</b>
2.1.1. Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах	
2.1.2. Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал	
2.1.3. Намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал	
2.1.4. Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал	
2.1.5. Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал	2,780.6
2.1.6. Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах	25,000.0
2.1.7. Цахим орчин ашиглах зардал	25,500.0
2.1.8. Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал	3,310.0
<b>2.2 Бусад зардлын дүн</b>	<b>11.9</b>

Сонгуулийн зардалд 56,590.6 мянган төгрөг, бусад зардалд 11.9 мянган төгрөг зарцуулсан байна.

## **2.2 Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив:**

Хандив өгч байгаа иргэний нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээлэл дутуу 5 иргэний 1,714.0 мянган төгрөгийг /Жаргалант сумын АН/ буцаах эсвэл улсын орлого болгоогүй зарцуулсан байна.

## **2.3 Сонгуулийн зардлын тайланд хийсэн аудитын илрүүлэлт:**

Аудитын хуулийн этгээдүүд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн А/55 дугаар тушаалаар баталсан “Сонгуулийн зардлыг тайлагнах заавар, аргачлал”, Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн А/19 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ын дагуу аудит хийж баталгаажуулсан тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газар дахин хянаж дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:



- Шударга - Иргэдийн нэгдсэн эвсэл нам сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй, Хөдөлмөрийн үндэсний нам сонгуулийн зардлын данс нээлгээгүй, зардал гаргаагүй тухай 2020.12.18-ны өдрийн 14 тоот албан бичгийг хуульд заасан хугацаанаас хойш ирүүлсэн, Монгол ардын хувьсгалт нам хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулалгүйгээр сонгуулийн зардлын дансанд орлого, зардал гараагүй тайлан ирүүлсэн;
- Жаргалант сумын Ардчилсан нам хандивлагчийн регистрийн дугаар, эх үүсвэр бичээгүй 1,714.0 мянган төгрөгийг буцаан шилжүүлээгүй, нийт 2,509.0 мянган төгрөгийг дансаа хааж бэлнээр авч зарцуулсан. Зардлын холбогдох анхан шатны баримтад иргэний худалдан авалтын сугалааны дугаартай баримт хавсаргасан.

Энэ нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-д “Нам, эвсэл болон нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэсэн өдрөөс эхэлж, сонгуулийн зардлын тайлан гаргах өдрийг дуусах хүртэл хугацаанд энэ хуулийн 38.2-т заасан арга хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа явуулах зориулалтаар сонгуулийн зардлын данснаас дансанд шилжүүлэх хэлбэрээр зарлага гаргаж болно.”, 53 дугаар зүйлийн 53.4-д “Хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээд нь нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээллээ банкны гүйлгээний баримтад тусгах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй хандивыг хандив хүлээн авагч буцаан шилжүүлнэ.”, 56 дугаар зүйлийн 56.3-д “Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

#### **2.4 Нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн мэдээлэл:**

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож буй намуудад /МАН/ 7 иргэн нийт 9,500.0 мянган төгрөгийн /нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив/ хандив өгсөн байна. Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 4-өөс үзнэ үү.

#### **2.5 Хувийн аудитын хуулийн этгээдийн дүгнэлт**

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцсон 2 намын /МАН, АН/ сонгуулийн зардлын тайланг аудитын хуулийн этгээдүүд үнэн зөв, иж бүрэн илэрхийлэгдсэн гэж дүгнэлт гаргасан байна.

### **ДҮГНЭЛТ**

#### **Нэр дэвшигчид:**

1. Сонгуулийн зардлын тайлангаа 42 нэр дэвшигч ирүүлээгүй байна.
2. Ирүүлсэн сонгуулийн зардлын тайлангийн 15 тайлан орлого, зарлага тайлагнаагүй “х” тайлан, 17 тайлан 3.0 мянган төгрөг хүртэлх төгрөгийн орлого, зардал тайлагнасан байна.
3. Сонгуулийн зардлын дансаа 2 нэр дэвшигч бүртгүүлээгүй байна.

4. Нийт 39 нэр дэвшигч хуулиар зөвшөөрөгдөөгүй 27,774.8 мянган төгрөгийн хандивыг сонгуулийн зардлын тайлан гаргахаас өмнө хандивлагч этгээдэд буцаагаагүй болон улсын орлого болголгүйгээр зарцуулсан байна.
5. Нэг нэр дэвшигч сонгуулийн зардлын дансаараа бус хувийн дансаараа 970.0 мянган төгрөгийн хандив хүлээн авч зарцуулсан ба нэр дэвшигчид сонгуульд оролцохтой холбоотой орлого, зардлын бүх гүйлгээгээ сонгуулийн зардлын дансаараа дамжуулж зарцуулсан эсэхийг бүрэн тодорхойлох боломжгүй байна.
6. Нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансны хуулгыг ХААН банкнаас бусад банкнууд ирүүлээгүй байна.

**Нам:**

- Жаргалант сумын Ардчилсан нам хуулиар зөвшөөрөгдөөгүй 1,714.0 мянган төгрөгийг хандивлагчид буцаан шилжүүлээгүй, нийт 2,509.0 мянган төгрөгийг дансаа хааж бэлнээр авч зарцуулсан байна.
- Шударга - Иргэдийн нэгдсэн эвсэл нам сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй, Хөдөлмөрийн үндэсний нам сонгуулийн зардлын данс нээлгээгүй, зардал гаргаагүй тухай албан бичгийг хуульд заасан хугацаанаас хойш ирүүлсэн, Монгол ардын хувьсгалт нам хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулалгүйгээр сонгуулийн зардлын дансанд орлого, зардал гараагүй тайлан ирүүлсэн байна.

**ЗӨВЛӨМЖ**

**Аймгийн ЗДТГ-н Санхүү, төрийн сангийн хэлтэс, Татварын хэлтэст:**

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн нам, эвсэл, нэр дэвшигчдэд Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 21, 25 дахь заалтыг хэрэгжүүлж холбогдох арга хэмжээ авч, хариуцлага тооцуулах.

**ХЯНАСАН:**


ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

**БЭЛТГЭСЭН:**

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

Огноо:

Б.ЭРДЭНЭ

Огноо:

Г.ОРГИЛМӨРӨН

Огноо:

Т.БОЛОРМАА

О.ГАНТУЯА

Б.АЗЖАРГАЛ

Г.ДАВААСҮРЭН

2021.01.13

2021.01.13

2021.01.13

## Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын санхүүжилт

/мянган төгрөг/

№	Тойргийн дугаар	Багийн нэр	Нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэр	Нэр дэвшигчийн овог нэр	Нийт орлогын дүн	Үүнээс:					
						Нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө	Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө	Хуулийн этгээдийн		Иргэний	
								Тоо	Өгсөн хандив	Тоо	Өгсөн хандив
<b>Орхон аймгийн ИТХ-ийн сонгуульд нэр дэвшигчид</b>											
1	1	Зэст	Монгол Ардын Нам	Б.Отгонбат	6,402.6	-	6,292.6	1.0	100.0	1.0	10.0
2	1	Зэст	Монгол Ардын Нам	Б.Цолмон	1,429.9	80.0	-	1.0	100.0	3.0	1,249.9
3	1	Зэст	Ардчилсан Нам	Б.Мягмарсүрэн	10,400.0	-	5,000.0	-	-	7.0	5,400.0
4	1	Зэст	Ардчилсан Нам	С.Юмэнхүү	8,165.7	-	367.0	-	-	17.0	7,798.7
5	1	Зэст	Бие даан нэр дэвшигч	Г.Ганбаатар	-	-	-	-	-	-	-
6	1	Зэст	Бие даан нэр дэвшигч	П.Түвшинжаргал	1,075.0	-	5.0	-	-	10.0	1,070.0
7	2	Оюут	Монгол Ардын Нам	Ж.Мөнх-Оргил	9,150.0	-	7,500.0	1.0	100.0	5.0	1,550.0
8	2	Оюут	Монгол Ардын Нам	М.Байгалмаа	9,303.0	100.0	3.0	-	-	7.0	9,200.0
9	2	Оюут	Ардчилсан Нам	Д.Баярмагнай	2,970.0	-	2,000.0	-	-	8.0	970.0
10	2	Оюут	Ардчилсан Нам	О.Мөнх-Од	1,740.0	-	-	-	-	13.0	1,740.0
11	2	Оюут	Бие даан нэр дэвшигч	Б.Төгсбаяр	3,755.0	-	-	-	-	22.0	3,755.0
12	2	Оюут	Бие даан нэр дэвшигч	Д.Тунгалаг	376.0	-	1.0	-	-	4.0	375.0
13	2	Оюут	Бие даан нэр дэвшигч	Д.Цэгмид	240.0	-	-	-	-	2.0	240.0
14	2	Оюут	Бие даан нэр дэвшигч	Ц.Чинбат	9,330.0	-	-	2.0	9,000.0	5.0	330.0
15	3	Уурхайчин	Монгол Ардын Нам	Г.Эрдэнэчулуун	12,340.2	-	790.2	1.0	1,000.0	10.0	10,550.0
16	3	Уурхайчин	Монгол Ардын Нам	Ц.Алтаншагай	14,820.0	-	481.0	-	-	15.0	14,339.0
17	3	Уурхайчин	Ардчилсан Нам	Б.Эрдэнбаяр	709.3	-	-	-	-	5.0	709.3
18	3	Уурхайчин	Ардчилсан Нам	Д.Өсөхбаяр	300.0	-	-	-	-	2.0	300.0
19	3	Уурхайчин	Бие даан нэр дэвшигч	Г.Пүрэвдорж	160.0	-	-	-	-	3.0	160.0
20	4	Хүрэнбулаг	Монгол Ардын Нам	Б.Мөнгөнтуяа	6,960.5	100.0	475.5	-	-	11.0	6,385.0
21	4	Хүрэнбулаг	Монгол Ардын Нам	Г.Эрдэнэбат	9,866.5	100.0	400.8	-	-	33.0	9,365.7
22	4	Хүрэнбулаг	Ардчилсан Нам	Д.Доржпүрэв	4,605.0	-	2,755.0	-	-	11.0	1,850.0
23	4	Хүрэнбулаг	Бие даан нэр дэвшигч	Д.Доржханд	170.0	-	-	-	-	3.0	170.0

24	4	Хүрэнбулаг	Бие даан нэр дэвшигч	Л.Алтангадас	-	-	-	-	-	-	-
25	4	Хүрэнбулаг	Бие даан нэр дэвшигч	Т.Хүрэлтогоо	870.0	-	-	-	-	15.0	870.0
26	5	Уртбулаг	Монгол Ардын Нам	Д.Бүүвэйбаатар	3,320.0	-	-	1.0	100.0	14.0	3,220.0
27	5	Уртбулаг	Монгол Ардын Нам	П.Баясгалан	7,560.0	-	-	1.0	100.0	20.0	7,460.0
28	5	Уртбулаг	Ардчилсан Нам	Г. Ганзориг	3,601.4	-	-	-	-	13.0	3,601.4
29	5	Уртбулаг	Ардчилсан Нам	Д.Энхзориг	2,100.1	-	1,600.1	-	-	5.0	500.0
30	5	Уртбулаг	Хөдөлмөрийн Үндэсний Нам	С.Дэнсмаа*	1,006.0	-	-	-	-	9.0	1,006.0
31	6	Согоот	Монгол Ардын Нам	Д.Эрдэнэбат	2,250.0	-	-	-	100.0	-	2,150.0
32	6	Согоот	Монгол Ардын Нам	Ө.Минжмаа	7,059.2	-	5,354.2	1.0	100.0	8.0	1,605.0
33	6	Согоот	Ардчилсан Нам	С.Эрхэмбаяр	1,658.0	-	-	-	-	13.0	1,658.0
34	6	Согоот	Ардчилсан Нам	Ц.Батхуяг	100.0	-	-	-	-	1.0	100.0
35	6	Согоот	Бие даан нэр дэвшигч	Д.Пүрэвсүрэн	560.0	-	-	-	-	11.0	560.0
36	6	Согоот	Бие даан нэр дэвшигч	Д.Эрдэнэжаргал	960.0	-	-	-	-	6.0	960.0
37	7	Дэнж	Монгол Ардын Нам	Д.Мөнхболд	14,893.9	-	-	3.0	2,600.0	36.0	12,293.9
38	7	Дэнж	Монгол Ардын Нам	Д.Ууганбаяр	12,165.0	-	11,305.0	1.0	500.0	6.0	360.0
39	7	Дэнж	Ардчилсан Нам	И.Баасанжав	100.0	-	-	-	-	1.0	100.0
40	8	Бүрэнбүст	Монгол Ардын Нам	В.Адъяа	8,710.0	-	1,610.0	1.0	100.0	11.0	7,000.0
41	8	Бүрэнбүст	Ардчилсан Нам	Р.Рагчаа	11,815.0	-	9,800.0	-	-	11.0	2,015.0
42	8	Бүрэнбүст	Бие даан нэр дэвшигч	Б.Эрдэнэхүү	460.0	-	-	-	-	4.0	460.0
43	9	Шанд	Монгол Ардын Нам	С.Батжаргал	9,100.0	-	-	1.0	100.0	6.0	9,000.0
44	9	Шанд	Ардчилсан Нам	С.Дангаасүрэн	400.0	-	-	-	-	4.0	400.0
45	10	Наран	Монгол Ардын Нам	Б.Мөнхдалай	10,456.3	100.0	3,286.3	-	-	4.0	7,070.0
46	10	Наран	Ардчилсан Нам	Т.Батбаатар	1,750.0	-	-	-	-	9.0	1,750.0
47	11	Цагаанчулуут	Монгол Ардын Нам	А.Түвшинжаргал	13,610.3	100.0	2,205.3	-	-	17.0	11,305.0
48	11	Цагаанчулуут	Монгол Ардын Нам	С. Ганцогт	11,288.6	100.0	2,186.0	-	-	39.0	9,002.6
49	11	Цагаанчулуут	Монгол Ардын Хувьсгалт Нам	Г.Оюунбат	-	-	-	-	-	-	-
50	12	Булаг	Монгол Ардын Нам	Б.Оюунбаяр	5,825.0	100.0	275.0	-	-	11.0	5,450.0
51	12	Булаг	Ардчилсан Нам	Э.Амарбаясгалан	9,660.0	-	310.0	-	-	21.0	9,350.0
52	13	Баянцагаан	Монгол Ардын Нам	Б. Баасансүрэн	9,452.8	-	-	1.0	100.0	17.0	9,352.8
53	13	Баянцагаан	Монгол Ардын Нам	Э.Батжаргал	11,185.1	100.0	184.1	-	-	47.0	10,901.0
54	13	Баянцагаан	Ардчилсан Нам	Б.Ганбат	1,517.0	-	137.0	-	-	11.0	1,380.0
55	13	Баянцагаан	Ардчилсан Нам	М.Балжинням	252.5	-	112.5	-	-	3.0	140.0
56	14	Говил	Монгол Ардын Нам	Б.Оюун-Эрдэнэ	9,996.7	-	305.3	1.0	100.0	21.0	9,591.4
57	14	Говил	Ардчилсан Нам	Д.Эрдэнэцогт	950.0	-	-	-	-	6.0	950.0
58	14	Говил	Бие даан нэр дэвшигч	П.Давхарбаяр	10.0	-	-	-	-	1.0	10.0
59	15	Рашаант	Монгол Ардын Нам	М.Түмэнжаргал	12,770.8	-	510.8	1.0	100.0	13.0	12,160.0

60	15	Рашаант	Монгол Ардын Нам	Ц.Гансүх	11,311.0	100.0	573.0	1.0	10,000.0	4.0	638.0
61	15	Рашаант	Ардчилсан Нам	Б.Бат-Эрдэнэ	2.7	-	-	-	-	-	2.7
62	15	Рашаант	Ардчилсан Нам	Б.Энхдэлгэр	1,360.3	-	480.3	-	-	9.0	880.0
63	15	Рашаант	Монгол Ардын Хувьсгалт Нам	П.Лхагвасүрэн	8,390.0	-	-	-	-	5.0	8,390.0
64	16	Эрдэнэ	Монгол Ардын Нам	Д.Мөнхбат	11,274.0	100.0	4.0	1.0	5,000.0	9.0	6,170.0
65	16	Эрдэнэ	Монгол Ардын Нам	С.Гандолгор	11,171.8	-	581.8	1.0	100.0	10.0	10,490.0
66	16	Эрдэнэ	Ардчилсан Нам	Б.Ариунболд	950.0	-	-	1.0	510.0	11.0	440.0
67	16	Эрдэнэ	Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсал Нам	Ч.Цэрэндагва	1,710.0	-	-	-	-	15.0	1,710.0
68	17	Баянбулаг	Монгол Ардын Нам	Х.Төгсбаяр	4,904.3	-	1,774.3	1.0	100.0	6.0	3,030.0
69	17	Баянбулаг	Ардчилсан Нам	Р.Улаанхүү	460.0	-	-	-	-	6.0	460.0
70	18	Их залуу	Монгол Ардын Нам	Х.Оюун-Эрдэнэ	9,770.9	100.0	5,962.0	-	-	11.0	3,708.9
71	18	Их залуу	Ардчилсан Нам	Я.Бэгэжав	1,040.0	-	-	-	-	9.0	1,040.0
72	18	Их залуу	Бие даан нэр дэвшигч	Ч.Бат-Ундрах	-	-	-	-	-	-	-
73	18	Их залуу	Бие даан нэр дэвшигч	П.Дүүриймаа	503.0	-	503.0	-	-	-	-
74	19	Даваат	Монгол Ардын Нам	Д.Дарханбаяр	6,960.9	100.0	6,322.0	-	-	12.0	538.9
75	20	Уртынгол	Монгол Ардын Нам	Ц.Баяржаргал	9,276.0	100.0	4,396.0	-	-	5.0	4,780.0
76	20	Уртынгол	Ардчилсан Нам	Д.Ганболд	1,280.0	-	-	-	-	12.0	1,280.0
77	21	Яргуйт	Монгол Ардын Нам	П.Ганзориг	7,569.0	-	2,489.0	-	-	9.0	5,080.0
78	21	Яргуйт	Монгол Ардын Хувьсгалт Нам	С. Энхтуяа	2,084.7	-	964.7	-	-	12.0	1,120.0
79	22	Яргуйт, Малчин	Монгол Ардын Нам	М.Майцэцэг	7,540.0	-	-	-	-	13.0	7,540.0
80	22	Яргуйт, Малчин	Монгол Ардын Хувьсгалт Нам	Н. Цог-Эрдэнэ	2,395.0	-	920.0	-	-	12.0	1,475.0
81	23	Жаргалант сум	Монгол Ардын Нам	Б.Зоригтбаяр	5,005.0	-	2,405.0	1.0	100.0	2.0	2,500.0
82	23	Жаргалант сум	Монгол Ардын Нам	П.Пүрэвлхагва	100.0	-	-	1.0	100.0	-	-
83	23	Жаргалант сум	Ардчилсан Нам	Г.Дуламханд	101.0	-	1.0	-	-	1.0	100.0
84	23	Жаргалант сум	Ардчилсан Нам	Д.Гантөмөр	4,590.0	-	2,000.0	-	-	15.0	2,590.0
<b>ДҮН</b>					<b>411,431.9</b>	<b>1,380.0</b>	<b>94,628.8</b>	<b>25.0</b>	<b>30,210.0</b>	<b>799.0</b>	<b>285,213.2</b>
<b>Орхон аймгийн Баян-Өндөр сумын ИТХ-ийн сонгуульд нэр дэвшигчид</b>											
85	1	Зэст	Монгол Ардын Нам	Д.Отгонжаргал	3,850.0	-	2,000.0	-	-	2.0	1,850.0
86	1	зэст	Монгол Ардын Нам	С.Баттулга	112.0	-	22.0	-	-	1.0	90.0
87	1	Зэст	Ардчилсан Нам	Б.Мөнхболд	1,150.0	-	-	-	-	9.0	1,150.0
88	1	Зэст	Ардчилсан Нам	Б.Чинзориг	3,678.0	-	238.0	-	-	17.0	3,440.0
89	2	Оюут	Монгол Ардын Нам	А.Бямбасүрэн	3,390.8	-	330.9	-	-	6.0	3,059.9
90	2	Оюут	Монгол Ардын Нам	Б.Ганданбалжир	6,250.0	-	6,200.0	-	-	1.0	50.0
91	2	Оюут	Ардчилсан Нам	Г.Баярсайхан	330.0	-	-	-	-	7.0	330.0

92	2	Оюут	Ардчилсан Нам	Д.Хүчитбаатар	673.0	-	25.0	-	-	11.0	648.0
93	3	Уурхайчин	Монгол Ардын Нам	Б.Жаргал	7,712.3	-	-	-	-	26.0	7,712.3
94	3	Уурхайчин	Монгол Ардын Нам	Ц.Шинэбаяр	3,058.0	-	-	-	-	6.0	3,058.0
95	3	Уурхайчин	Ардчилсан Нам	Б.Билгүүн	480.0	-	40.0	-	-	5.0	440.0
96	3	Уурхайчин	Ардчилсан Нам	С.Бат-Эрдэнэ	989.9	-	-	-	-	12.0	989.9
97	3	Уурхайчин	Монгол Ардын Хувьсгалт Нам	П.Баттөр	0.5	-	0.5	-	-	-	-
98	4	Хүрэнбулаг	Монгол Ардын Нам	Г.Сайн-Итгэл	3,840.0	-	980.0	-	-	20.0	2,860.0
99	4	Хүрэнбулаг	Монгол Ардын Нам	Ц.Оюунцэцэг	8,509.4	-	-	1.0	8,209.4	1.0	300.0
100	4	Хүрэнбулаг	Ардчилсан Нам	Б.Батгэрэл	1,816.3	-	1,596.3	-	-	3.0	220.0
101	4	Хүрэнбулаг	Ардчилсан Нам	Ч.Гэрэлтуяа	1,420.0	-	-	-	-	22.0	1,420.0
102	5	Уртбулаг	Монгол Ардын Нам	С.Бямба-Оргил	2,156.2	-	76.2	-	-	2.0	2,080.0
103	5	Уртбулаг	Ардчилсан Нам	Г.Цэнгэлмаа	806.5	-	806.5	-	-	-	-
104	6	Согоот	Монгол Ардын Нам	Д.Шинэбаатар	3,635.5	-	1,485.5	-	-	3.0	2,150.0
105	6	Согоот	Ардчилсан Нам	Б.Лхагвасүрэн	1,800.5	-	-	-	-	15.0	1,800.5
106	6	Согоот	Монгол Ардын Нам	Р.Мөнхбаатар	3,627.0	-	-	-	-	7.0	3,627.0
107	6	Согоот	Ардчилсан Нам	Ц.Оргилболд	800.0	-	-	-	-	8.0	800.0
108	7	Дэнж	Монгол Ардын Нам	Г.Энхбаяр	4,972.0	-	22.0	-	-	14.0	4,950.0
109	7	Дэнж	Монгол Ардын Нам	Ч.Болор-Эрдэнэ	6,870.0	-	3,610.0	-	-	5.0	3,260.0
110	7	Дэнж	Ардчилсан Нам	Г.Батбаатар	1,100.0	-	-	-	-	11.0	1,100.0
111	7	Дэнж	Ардчилсан Нам	Н.Мөнгөн	400.0	-	40.0	-	-	12.0	360.0
112	8	Бүрэнбүст	Монгол Ардын Нам	М.Баярбаясгалан	3,020.0	-	3,020.0	-	-	-	-
113	8	Бүрэнбүст	Ардчилсан Нам	З.Хатанбаатар	2,876.0	-	556.0	-	-	12.0	2,320.0
114	8	Бүрэнбүст	Монгол Ардын Хувьсгалт Нам	Ч.Ариунгэрэл	601.0	-	1.0	-	-	4.0	600.0
115	9	Шанд	Монгол Ардын Нам	Ц.Мөнхмандах	2,830.4	-	650.0	-	-	6.0	2,180.4
116	9	Шанд	Ардчилсан Нам	Ү.Туулсайхан	554.4	-	354.4	-	-	1.0	200.0
117	10	Наран	Ардчилсан Нам	Н.Азжаргал	1,698.8	-	-	-	-	20.0	1,698.8
118	10	Наран	Монгол Ардын Нам	С.Эрдэнэбаяр	2,298.3	-	2,298.3	-	-	-	-
119	11	Цагаанчулуут	Монгол Ардын Нам	Б.Мөнхзаяа	4,901.3	-	126.3	-	-	6.0	4,775.0
120	11	Цагаанчулуут	Монгол Ардын Хувьсгалт Нам	Б.Түмэнжаргал	-	-	-	-	-	-	-
121	11	Цагаанчулуут	Монгол Ардын Нам	Э.Эрдэнэбат	3,525.0	-	3,500.0	-	-	2.0	25.0
122	12	Булаг	Монгол Ардын Нам	Г.Отгонбаатар	3,835.3	-	3,635.3	-	-	1.0	200.0
123	13	Баянцагаан	Монгол Ардын Нам	Г.Наранжав	5,065.3	-	180.3	-	-	6.0	4,885.0
124	13	Баянцагаан	Монгол Ардын Нам	О.Амарсайхан	8,366.0	-	8,261.0	-	-	4.0	105.0
125	13	Баянцагаан	Ардчилсан Нам	Ч.Эрдэнэбат	440.0	-	-	-	-	9.0	440.0
126	14	Говил	Монгол Ардын Нам	Ц.Одгэрэл	3,575.0	-	2,985.0	-	-	5.0	590.0

127	14	Говил	Ардчилсан Нам	Т.Мөнхбат	1,170.0	-	400.0	-	-	9.0	770.0
128	15	Рашаант	Монгол Ардын Нам	Ж.Энхсайхан	6,868.0	-	-	-	-	17.0	6,868.0
129	15	Рашаант	Монгол Ардын Нам	С.Эрдэнэчимэг	8,458.7	-	238.7	-	-	8.0	8,220.0
130	15	Рашаант	Ардчилсан Нам	П.Цэдэвдорж	700.0	-	-	-	-	3.0	700.0
131	16	Эрдэнэ	Монгол Ардын Нам	Н.Отгонбилэг	9,620.0	-	-	-	-	8.0	9,620.0
132	16	Эрдэнэ	Монгол Ардын Нам	Т.Эрдэнэбат	9,622.0	-	5,542.0	-	-	13.0	4,080.0
133	16	Эрдэнэ	Ардчилсан Нам	Л.Баярсайхан	-	-	-	-	-	-	-
134	16	Эрдэнэ	Ардчилсан Нам	П.Баасанхүү	1,110.0	-	1,060.0	-	-	1.0	50.0
135	17	Баянбулаг	Монгол Ардын Нам	Б.Очирцэрэн	3,838.0	-	1,698.0	-	-	10.0	2,140.0
136	17	Баянбулаг	Ардчилсан Нам	З.Эркебулан	211.1	-	-	-	-	2.0	211.1
137	18	Их залуу	Монгол Ардын Нам	Э.Пунсалдулам	5,800.0	-	-	-	-	4.0	5,800.0
138	18	Их залуу	Монгол Ардын Хувьсгалт Нам	Э.Энхчимэг	-	-	-	-	-	-	-
139	18	Их залуу	Бие даан нэр дэвшигч	П.Мөнхсүрэн	-	-	-	-	-	-	-
140	19	Даваат	Монгол Ардын Нам	М.Ууганбаяр	3,100.0	-	2,980.0	-	-	3.0	120.0
141	19	Даваат	Ардчилсан Нам	Т.Сугар	2,231.5	-	-	-	-	5.0	2,231.5
142	19	Даваат	Монгол Ардын Хувьсгалт Нам	Г.Нарангэрэл	-	-	-	-	-	-	-
143	20	Уртынгол	Монгол Ардын Нам	А.Баясгалан	-	-	-	-	-	-	-
144	20	Уртынгол	Ардчилсан Нам	О.Отгонтөгс	2,098.0	-	42.0	-	-	26.0	2,056.0
145	21	Яргуйт, Малчин	Монгол Ардын Нам	Ц.Отгонбаяр	8,509.5	-	2,109.5	-	-	6.0	6,400.0
146	22	Яргуйт, Малчин	Ардчилсан Нам	Ц.Батмөнх	270.2	-	0.2	-	-	3.0	270.0
<b>ДҮН</b>					<b>180,621.7</b>	<b>-</b>	<b>57,110.9</b>	<b>1.0</b>	<b>8,209.4</b>	<b>420.0</b>	<b>115,301.4</b>
<b>Орхон аймгийн Жаргалант сумын ИТХ-ийн сонгуульд нэр дэвшигчид</b>											
147	1	Улаантолгой	Монгол Ардын Нам	Б.Цогт-Очир	1.0	-	-	-	-	1.0	1.0
148	1	Улаантолгой	Монгол Ардын Нам	Д.Мягмарсүрэн	1.0	-	1.0	-	-	-	-
149	1	Улаантолгой	Монгол Ардын Нам	Н.Хадаа	1.0	-	1.0	-	-	-	-
150	1	Улаантолгой	Монгол Ардын Нам	П.Барсболд	1.0	-	1.0	-	-	-	-
151	1	Улаантолгой	Монгол Ардын Нам	Ч.Сувдаа	-	-	-	-	-	-	-
152	1	Улаантолгой	Монгол Ардын Нам	Ш.Билгүүнбаатар	-	-	-	-	-	-	-
153	1	Улаантолгой	Монгол Ардын Нам	Я.Моломдагва	501.2	-	101.2	-	-	2.0	400.0
154	1	Улаантолгой	Ардчилсан Нам	Г.Цогзолмаа	1.0	-	1.0	-	-	-	-
155	1	Улаантолгой	Ардчилсан Нам	Н.Жарантай	1.0	-	1.0	-	-	-	-
156	2	Жаргалант	Монгол Ардын Нам	Г.Баттогтох	-	-	-	-	-	-	-
157	2	Жаргалант	Монгол Ардын Нам	Ж.Эрдэнэ-Очир	-	-	-	-	-	-	-
158	2	Жаргалант	Монгол Ардын Нам	З.Ганбилэг	120.0	-	-	-	-	1.0	120.0
159	2	Жаргалант	Монгол Ардын Нам	Л.Учрал	401.0	-	1.0	-	-	4.0	400.0
160	2	Жаргалант	Монгол Ардын Нам	П.Буянбат	-	-	-	-	-	-	-

161	2	Жаргалант	Монгол Ардын Нам	Т.Лхагвацэрэн	121.0	-	1.0	-	-	2.0	120.0
162	2	Жаргалант	Монгол Ардын Нам	Х.Энхжаргал	1.0	-	-	-	-	1.0	1.0
163	2	Жаргалант	Ардчилсан Нам	Д.Эрдэнэтуяа	20.0	-	-	-	-	1.0	20.0
164	2	Жаргалант	Ардчилсан Нам	Н.Цэцэгсүрэн	1.0	-	1.0	-	-	-	-
165	2	Жаргалант	Ардчилсан Нам	Э.Мөнхнасан	1.0	-	1.0	-	-	-	-
166	3	Дулаан-Уул	Монгол Ардын Нам	Д.Уранчимэг	20.0	-	-	-	-	1.0	20.0
167	3	Дулаан-Уул	Монгол Ардын Нам	Ж.Алтантөгс	1.0	-	1.0	-	-	-	-
168	3	Дулаан-Уул	Монгол Ардын Нам	Ж.Дэлхийцэцэг	1.0	-	1.0	-	-	-	-
169	3	Дулаан-Уул	Монгол Ардын Нам	Л.Ганбат	80.0	-	-	-	-	2.0	80.0
170	3	Дулаан-Уул	Монгол Ардын Нам	С.Балжинням	1.0	-	1.0	-	-	-	-
171	3	Дулаан-Уул	Монгол Ардын Нам	С.Эрдэнэчимэг	1.0	-	1.0	-	-	-	-
172	3	Дулаан-Уул	Ардчилсан Нам	Н.Сэлэнгэмаа	1.0	-	1.0	-	-	-	-
<b>ДҮН</b>					<b>1,277.2</b>	-	<b>115.2</b>	-	-	<b>15.0</b>	<b>1,162.0</b>
<b>НИЙТ ДҮН</b>					<b>593,330.8</b>	<b>1,380.0</b>	<b>151,854.9</b>	<b>26.0</b>	<b>38,419.4</b>	<b>1,234.0</b>	<b>401,676.5</b>

\* Хугацаа хоцроож ирүүлсэн





25	4	Хүрэнбулаг	Бие даан нэр дэвшигч	Т.Хүрэлтогоо	870.0	635.0	-	-	-	204.2	-	-	30.0	0.8
26	5	Уртбулаг	Монгол Ардын Нам	Д.Бүүвэйбаатар	3,320.0	789.0	-	-	-	1,848.5	-	675.0	-	7.5
27	5	Уртбулаг	Монгол Ардын Нам	П.Баясгалан	7,074.9	1,830.0	589.6	-	-	4,650.0	-	-	-	5.3
28	5	Уртбулаг	Ардчилсан Нам	Г.Ганзориг	3,601.4	850.0	-	-	-	1,800.0	100.0	-	250.0	601.4
29	5	Уртбулаг	Ардчилсан Нам	Д.Энхзориг	2,100.1	1,000.0	-	-	-	1,099.0	-	-	-	1.1
30	5	Уртбулаг	Хөдөлмөрийн Үндэсний Нам	С.Дэнсмаа*	1,006.0	389.4	-	-	-	615.0	-	-	-	1.6
31	6	Согоот	Монгол Ардын Нам	Д.Эрдэнэбат	2,145.0	-	-	-	-	2,140.0	-	-	-	5.0
32	6	Согоот	Монгол Ардын Нам	Ө.Минжмаа	7,055.6	5,080.0	-	-	-	1,971.2	-	-	-	4.4
33	6	Согоот	Ардчилсан Нам	С.Эрхэмбаяр	1,658.0	1,100.0	558.0	-	-	-	-	-	-	-
34	6	Согоот	Ардчилсан Нам	Ц.Батхуяг	100.0	-	-	-	-	99.6	-	-	-	0.4
35	6	Согоот	Бие даан нэр дэвшигч	Д.Пүрэвсүрэн	560.0	-	-	-	-	160.0	-	-	400.0	-
36	6	Согоот	Бие даан нэр дэвшигч	Д.Эрдэнэжаргал	954.0	602.0	-	-	-	349.4	-	-	-	2.6
37	7	Дэнж	Монгол Ардын Нам	Д.Мөнхболд	14,893.7	9,249.0	-	-	-	5,636.5	-	-	-	8.2
38	7	Дэнж	Монгол Ардын Нам	Д.Ууганбаяр	12,164.3	5,000.0	-	-	-	7,158.0	-	-	-	6.3
39	7	Дэнж	Ардчилсан Нам	И.Баасанжав	100.0	-	-	-	99.8	-	-	-	-	0.2
40	8	Бүрэнбүст	Монгол Ардын Нам	В.Адъяа	8,707.4	5,400.0	-	-	-	3,300.0	-	-	-	7.4
41	8	Бүрэнбүст	Ардчилсан Нам	Р.Рагчаа	11,815.0	3,000.0	1,000.0	-	250.0	1,400.0	29.5	-	853.5	5,282.0
42	8	Бүрэнбүст	Бие даан нэр дэвшигч	Б.Эрдэнэхүү	460.0	259.0	-	-	-	-	200.0	-	-	1.0
43	9	Шанд	Монгол Ардын Нам	С.Батжаргал	9,099.2	5,484.0	-	-	-	3,610.0	-	-	-	5.2
44	9	Шанд	Ардчилсан Нам	С.Дангаасүрэн	399.3	399.0	-	-	-	-	-	-	-	0.3
45	10	Наран	Монгол Ардын Нам	Б.Мөнхдалай	10,456.3	5,000.0	-	-	-	2,296.0	3,086.0	-	66.2	8.1
46	10	Наран	Ардчилсан Нам	Т.Батбаатар	1,746.1	-	-	-	-	1,745.0	-	-	-	1.1
47	11	Цагаанчулуут	Монгол Ардын Нам	А.Түвшинжаргал	7,462.9	853.0	-	-	-	4,346.0	-	-	2,255.0	8.9
48	11	Цагаанчулуут	Монгол Ардын Нам	С.Ганцогт	11,288.6	5,320.0	-	-	-	2,903.1	-	-	3,057.5	8.0
49	11	Цагаанчулуут	Монгол Ардын Хувьсгалт Нам	Г.Оюунбат	-	-	-	-	-	-	-	-	-	-
50	12	Булаг	Монгол Ардын Нам	Б.Оюунбаяр	5,825.0	2,794.1	-	-	-	3,025.0	-	-	-	5.9
51	12	Булаг	Ардчилсан Нам	Э.Амарбаясгалан	9,659.2	2,440.4	-	-	-	7,213.0	-	-	-	5.8
52	13	Баянцагаан	Монгол Ардын Нам	Б.Баасансүрэн	9,430.8	5,000.0	-	-	-	4,410.0	-	-	-	20.8
53	13	Баянцагаан	Монгол Ардын Нам	Э.Батжаргал	11,034.3	9,685.0	-	-	-	630.0	-	-	713.2	6.1
54	13	Баянцагаан	Ардчилсан Нам	Б.Ганбат	1,507.4	-	-	-	-	1,507.4	-	-	-	-
